



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/124

Эрдэнэт

Шагнах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172-р тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 4.1.6, аймгийн Засаг даргын 2012 оны 560 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын журам”-ын 3.1, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Наурызын баярын өдрийг тус тус тохиолдуулан хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан хавсралтад дурьдсан нэр бүхий иргэдийг Орхон аймгийн “Хүндэт тэмдэг”, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсугай.

2. Шагналд зарцуулагдах 1600000 /нэг сая зургаан зуун мянган/ төгрөгийг орон нутгийн бусад зардлын шагнал урамшууллын сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ